



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯМНЫ
САЙДЫН ТУШААЛ

2002 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 363

Улаанбаатар хот

Гадаадад суралцуудах тухай

2002-2003 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн тушаах нь:

1. 2002-2003 оны хичээлийн жилээс Маналжав овогтой Золжаргалыг АНУ-ын Калифорни их сургуулийн магистрантурт хууль, эрх зүйн мэргэжлийн чиглэлээр, Адъяасурэн овогтой Заяадэлгэрийг Австрали Улсын Виктория их сургуулиин магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар тус тус суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу эдгээр суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасурэн/, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД-г С.Эрдэнэгүй А.ЦАНЖИД